



for a living planet*

Дэлхийн Байгаль Хамгаалах Сан (WWF)-ийн
Монгол дахь Хөтөлбөрийн газар
Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Амарын гудамж, Интер оффис 400
Утас: +(976)-11-311659
Цахим шуудан: info@wwf.mn

2024 он 1 сарын 5-ний өдөр

№ 3/780

Улаанбаатар

ШУГАМАН ДЭД БҮТЦИЙН ТАЛААР АЖИЛЛАДАГ ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН БАЙГУУЛЛАГУУДААС САНАЛ ИРҮҮЛЭХ ХҮСЭЛТ ХҮРГҮҮЛЭХ НЬ

Монгол Улсад шугаман дэд бүтцийн бүтээн байгуулалт эрчимжиж байгаагаас шалтгаалан зэрлэг амьтад, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэл нэмэгдэж байна. Энэхүү нөхцөл байдлыг арилгах зорилгоор Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-ийн Монгол дахь хөтөлбөрийн газраас “Asia’s linear infrastructure safeguarding nature (ALIGN)” төслийн хүрээнд “Зэрлэг амьтдад ээлтэй шугаман дэд бүтцийг хөгжүүлэх мэдлэгийг олгох сургалтын агуулга, материал боловсруулах” ажлыг гүйцэтгэхээр зөвлөх багтай гэрээ байгуулан ажиллаж байгаа билээ. Энэхүү ажлын үндсэн зорилго нь зэрлэг амьтдад ээлтэй шугаман дэд бүтцийг хөгжүүлэх чиглэлээр төр, хувийн хэвшлийн шийдвэр гаргагчид, болон холбогдох мэргэжилтнүүд, албан хаагчдыг чадавхжуулах сургалтын багцыг бий болгох юм. Дээрх сургалтын багцыг бий болгосноор төр, хувийн хэвшлийн байгууллагууд богино хугацаанд албан хаагчдаа сургах, зохиох мэдлэгийг нь дээшлүүлэх бүрэн боломжтой болох юм.

Тус сургалтын багц нь үндсэн 5 модулиас бүрдэхээр төлөвлөгдөж байгаа бөгөөд дараах агуулгатай байна. Үүнд:

- **Модуль 1: Зэрлэг амьтдын шилжилт хөдөлгөөний хэв маяг, шалтгаан, экологийн холбоос нутгийн тухай суурь ойлголтууд**
- **Модуль 2: Зэрлэг амьтдад үзүүлэх шугаман дэд бүтцийн сөрөг нөлөө, түүнийг тогтоох нь**
- **Модуль 3: Шугаман дэд бүтцийн сөрөг нөлөөг бууруулах арга замууд**
- **Модуль 4: Шугаман дэд бүтцийн сөрөг нөлөөг бууруулах сайн жишээнүүд**
- **Модуль 5: Шугаман дэд бүтцийн сөрөг нөлөөг бууруулахтай холбоотой дүрэм, журам, хууль эрх зүйн үндэслэл**

Энэхүү сургалтын нийт үргэлжлэх хугацаа нь 4-6 цаг байх бөгөөд дагалдах видео хичээлтэй байна.

Та бүхэн дээрх сургалтын агуулгатай танилцаад өөрсдийн зүгээс шаардлагатай мэдлэг олгогдох эсэхийг тодорхойлж зайлшгүй нэмэх эсвэл өөрчлөх шаардлагатай санал байвал бидэнд 2024 оны 1 сарын 15-ний дотор энэхүү албан бичиг очсон цахим шууданд саналаа хариу болгон ирүүлж бидэнтэй хамтран ажиллана уу. Бид та бүхний ирүүлсэн саналыг анхааран судалж сургалтын багцын төслийг сайжруулах ажлыг хийх болно.

Хүндэтгэсэн, Байгаль хамгааллын захирал

Б.ЧИМЭДДОРЖ

